



## ШИНЖЭЭЧИЙН БАГИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль

Гадаад хэлний сургууль

Хөтөлбөрийн нэр: Гадаад хэлний орчуулга ( Хятад хэл)

Индекс: D032101 Бакалавр

Шинжээчийн баг:

Ахлагч: Д.Эрдэнэсүрэн (Ph.D)

Гишүүд: Д.Ундрах (Ph.D)

Ц.Дэлгэрэхцэцэг (Ph.D)

Б.Туяа (Ph.D)

Э.Номин (Ph.D)

Он сар өдөр:2023.11.27

### Агуулга

**Товчилсон үгийн тайлбар**

**I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт**

**II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга**

**III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт**

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

#### **IV. Уулзалтад оролцогчдын нэрс**

I. Оюутнуудын нэрс

II. Багш, ажилчдын нэрс

III. Төгсөгчдийн нэрс

IV. Ажил олгогчдын нэрс

#### **V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**

#### **VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр**

#### **VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр**

## Товчилсон үгийн тайлбар

### I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

<b>Сургуулийн нэр /Монгол, Англи/</b>	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн Гадаад хэлний сургууль	
<b>Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/</b>	Гадаад хэлний орчуулга (Япон, солонгос, хятад хэл)	
<b>Индекс</b>	Бакалавр	
<b>Шинжээчид</b>	<p>Ахлагч: Д.Эрдэнэсүрэн Хүмүүнлэгийн Ухааны Их Сургуулийн Гадаад хэлний тэнхимийн профессор</p> <p>Гишүүд: Д.Ундрах Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Ази судлалын тэнхимийн дэд профессор Ц.Дэлгэрэхцэцэг Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Ази судлалын тэнхимийн дэд профессор Б.Туяа Олон Улсын Улаанбаатарын Их Сургуулийн Солонгос хэлний боловсролын тэнхимийн эрхлэгч Э.Номин Отгонтэнгэр Их Сургуулийн Хүмүүнлэгийн сургуулийн дэд профессор</p>	
<b>БМИҮЗ-ийн зохицуулагч</b>	Магадлан итгэмжлэл хариуцсан шинжээч П.Оргилмаа	
<b>Төлөвлөгөө</b>	<b>Он сар өдөр</b>	<b>Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/</b>
	2023.11.03	Шинжээчидтэй гэрээ байгуулах
	2023.11.06	Шинжээчдэд өөрийн үнэлгээний тайланг хавсралтын хамт хүлээлгэн өгнө.
	2023.11.14	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2023.11.16, 17	Шинжээчид сургууль дээр ажиллана.
	2023.11.27	Шинжээчид үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.

	2023.11.28	Сургууль үнэлгээний тайлантай танилцаж, тайлбар, нотлох баримтыг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2023.11.30	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ.
	Хуваарьт хуралдаан	Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар шинжээчийн үнэлгээний тайланг танилцуулж шийдвэрлүүлнэ.
<b>Шалгуур шаардлага /журам/</b>	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ы өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлага”	

## II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

ГХС-ийн Ази судлалын салбар хариуцан хэрэгжүүлдэг. Өнөөдрийн ГХС-ийн Ази судлалын салбар, Хэрэглээний хэл шинжлэлийн салбар, Англи хэлний тэнхим 87 профессор багш, ажилтантай, эдгээрээс академич 1, шинжлэх ухааны доктор 1, доктор /Ph.D/ 30 байна. Мөн тус сургуулийн дэргэд Англи хэлний академи,

“Русский мир”, “Солонгос хэлний смарт анги” зэрэг мэдээллийн технологид суурилсан англи, орос, солонгос хэлний сургалтын лаборатори төвүүд ажиллаж, TOEFL, TORFL, GMAT, J.TEST зэрэг англи, орос, япон хэлний түвшин тогтоох шалгалтыг албан ёсны эрхтэйгээр тогтмол зохион байгуулдаг. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд бакалаврын зэрэгтэй 1557, магистрын зэрэгтэй 245 мэргэжилтэн бэлтгэн төгсгөсөн, 60 гаруй судлаач тус сургуулийн докторын сургалтыг дүүргэсэн байна.

## III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

### Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

#### 1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

**Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийн төлөвлөлтийг PDCA, мэргэжлийн хэрэгцээ шаардлагыг тандах зорилгоор STEEP шинжилгээг тус тус хийж хүснэгтээр хавсаргасан.
- Хятад хэлний салбар нь хөтөлбөрийг боловсруулахдаа ШУТИС-ийн Гадаад хэлний орчуулга /Хятад / хөтөлбөрийг Гадаад, дотоодын их дээд сургуультай харьцуулсан. Үүнд: БНХАУ-ын Гадаад хэлний Их сургуулийн Орчуулга мэргэжил /англи хэл/, БНХАУ-ын Уханий их сургуулийн Гадаад хэл, утга зохиолын сургуулийн Орчуулга мэргэжил /англи хэл/-ний хөтөлбөртэй, МУИС-ийн Гадаад хэлний орчуулга /Хятад/, ОТИС-ийн Гадаад хэлний орчуулга /Хятад/ хөтөлбөртэй тус тус харьцуулан боловсруулсан.
- Хөтөлбөрийн мэргэжлийн суурь хичээлүүдийн багц ижил төстэй гадаадын дотоодын сургуулиудын хөтөлбөрийн хичээлүүдийн орчуулгын хичээлийн агуулгатай ерөнхийдөө ойролцоо байна.
- ШУТИС-ийн ГХС-ийн “Гадаад хэлний орчуулга” /хятад/ хөтөлбөрт барилга, эрчим хүч, зам гүүр, хүнс, биотехнологи, уул уурхай, механик зэрэг техник технологийн чиглэл давамгайлсан орчуулгын хичээл багтсанаараа бусад хөтөлбөрөөс онцлог байна.
- Мэргэжлийн боловсролын хөтөлбөр, хичээлийн хөтөлбөрийг оролцогч, сонирхогч талуудын сэтгэл ханамжийн судалгаанд тулгуурлан өөрчлөлт шинэчлэлт хийдэг. Үүнд: Хөтөлбөрийн зорилго, төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг оролцогч талуудын саналыг тусгаж, өөрчлөлт шинэчлэлт хийсэн. Үүнд: 1995-1996 оны хичээлийн жил Орчуулагч инженер, D541401; Инженер багш D220300 1999-2000 оны хичээлийн жил Гадаад хэлний орчуулга, D220300 2007-2008 оны хичээлийн жил Техникийн мэргэжлийн орчуулга, D220710 2016-2017 оны хичээлийн жил Гадаад хэлний орчуулга, D032101 гэсэн индекстэй Цахим сургалт шилжилтийн газраас өгсөн журмын дагуу 2016 онд,хөтөлбөрөө боловсруулж 2023 оны хавар шинэчлэх ажил эхэлсэн байна.
- Эх хэлний мэдлэг боловсролыг мэргэжлийн түвшинд олгоход чухал үүрэг гүйцэтгэх монгол хэлний багц хичээл /хэл ярианы соёл, монгол бичиг, монгол хэлний хэл зүй, үгийн сан, шинжлэх ухааны найруулга, нэр томъёо судлал: 8-9 кредит/ хөтөлбөрт тусгагдсан нь бас нэг онцлог мөн байна.
- 2017-2021 оны хичээлийн жилийн турш жил бүр төгсөгчдийн мөшгөх судалгааг явуулж, ажил эрхлэлтийн судалгааг хийж хөтөлбөрийн шинэчлэлийг хийсэн.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хятад, хэлний орчуулагчийн эрэлт хэрэгцээг гаргахаар Дотоодын бусад сургуулийн ижил төстэй хөтөлбөрүүдтэй харьцуулахад техникийн орчуулгын хичээл 21 кредит цаг үздэг, сургалт явуулдаг зэрэг нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд онцлог нь тал болж байна.
- “Техник технологийн орчуулга” хичээлээр салбар шинжлэх ухаанууд болох барилга, эрчим хүч, зам гүүр, хүнс биотехнологи, уул уурхай, техникийн хятад, солонгос, япон хэлээрэг техник технологийн чиглэлийн орчуулга орчуулагч бэлтгэн гаргадгаараа маш онцлогтой байна.

### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн бэнчмарк судалгааг Хятад хэлний хөтөлбөр зөвхөн БНХАУ-ын их сургуулиудтай харьцуулсан нь хангалтгүй.
- Тайланд шинжлэх ухааны тодорхой чиглэлээр мэргэшсэн хэлмэрч, орчуулагч дутагдалтай байгаа. Чухамхүү эдгээр эрэлт, хэрэгцээнээс үүдэн техник технологийн чиглэлийн мэдлэг чадвартай солонгос хэлний орчуулагч бэлтгэн гаргах шаардлага байсаар байна хэмээн дүгнэсэн ч үндэслэсэн судалгаа нотлох баримт нь тодорхойгүй.

### **Зөвлөмж:**

- Болж өгвөл техникийн орчуулгын мэргэшил олгодог хөтөлбөрүүдтэй харьцуулж өөрсдийн онцлогоо гарган дүгнэх.
- Европ, Америк, Азийн өндөр түвшний их дээд сургуулиудын ижил төстэй, гадаад хэлний орчуулагч бэлддэг хөтөлбөрүүдтэй харьцуулж үзэх шаардлагатай.
- Зөвхөн хичээлийн нэр төрлийн түвшинд бус, хичээлийн хөтөлбөрийн агуулгыг харьцуулсны үндсэн дээр сургалтын хөтөлбөрөө улам сайжруулах тал дээр судалгаа хийх шаардлагатай байна.

### **1.2 Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийн зорилгоо сургуулийн эрхэм зорилго, стратеги төлөвлөгөөний зорилтуудтай уялдуулан тодорхойлсон.

- Хөтөлбөрийн зорилго зорилтыг тодорхойлж хөтөлбөрөөр эзэмшүүлэх мэдлэг чадвар болон хөтөлбөрийн зорилго зорилтууд хоорондын уялдаа, холбоог гаргасан.
- Хөтөлбөрийн зорилгын дагуу зорилтуудыг дэвшүүлж ажилладаг ба хөтөлбөрөөр эзэмших суурь мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлсон байна.
- Хөтөлбөрийн зорилго, зорилтууд болон эзэмших мэдлэг, чадварын хоорондын уялдаа холбоог Course Learning Outcomes загвараар тодорхойлох оролдлого хийсэн байна.
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөө, график, хөтөлбөрийн болон хичээлийн суралцахуйн үр дүнгийн төлөвлөлтийг уялдуулж боловсруулсан.
- Хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадварын жагсаалтыг гаргасан.
- Төгсөгчийн загварыг гаргасан.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- CDIO стандарт, арга зүй нэвтрүүлсэн сургалтын хөтөлбөрөөр төгсөгчийн загвар гаргасан.
- 2019 онд CDIO стандартын үзүүлэлтээр өөрийн үнэлгээний тайлан гаргасан.
- Гадаад хэлний орчуулга хөтөлбөр хэрэгжүүлэхдээ техникийн мэргэжлийн хичээлүүдийг дөрвөн салбараар хувааж мэргэшүүлэн орохоор хөтөлбөртөө тусгаж, ШУТИС-ийн баримталж буй бодлогод нийцүүлэн боловсруулсан.

#### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрөөр төгсөгчийн боломжит ажлын байрыг тодорхойлоогүй.
- Хөтөлбөрийн зорилтод төгсөгчийн хүрэх гадаад хэлний түвшинг тодорхойлоогүй.
- Хөтөлбөрийг шинэчлэхэд оролцогч талуудын судалгаа 2016 оноос хойш хийгдээгүй, хөтөлбөрийг боловсруулж, сайжруулахад яг ямар саналуудыг тусгасан нь тодорхойгүй, тайланд ерөнхий бичсэн байна.

## **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн зорилтдоо төгсөгчийн хүрэх гадаад хэлний түвшинг оруулж өгөх. Үүндээ Европыг олон хэлний стандартыг баримтлах.
- Хөтөлбөрөөр төгсөгчийн боломжит ажлын байрыг тодорхойлж, хөрвөх чадварыг тодорхой болгох.
- Хөтөлбөрийг шинэчлэхэд оролцогч талуудын судалгааг хийж, хөтөлбөрийг боловсруулж, сайжруулахад яг ямар саналуудыг тусгасаныг нь тодорхой болгох шаардлагатай.

### **1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

## **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөр төлөвлөлтийн баримт бичгийн жагсаалт хийсэн.
- Сургуулийн хэмжээнд нэгдсэн нэг стандартаар хичээл тус бүр дээр хичээлийн хөтөлбөр боловсруулдаг, хичээлийн хөтөлбөрийг тайланд хавсаргасан.
- Хичээлийн хөтөлбөрийг тухайн хичээлийг хариуцсан мэргэжлийн тэнхимээс эрх олгосон багш нар боловсруулж, хөтөлбөрийн хороо шалган баталгаажуулдаг.
- Хөтөлбөр сургалтын төлөвлөгөөний хичээл хоорондын залгамж холбоог харуулсан схем хийсэн. Хүснэгт 1.11
- Өөрийн үнэлгээний тайланд SWOT шинжилгээ хийсэн.

## **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Оюутны дадлагыг ажил олгогч байгууллага, техникийн мэргэжлийн компаниудад хийдэг нь хамт олны дунд орж ажиллах, техникийн гадаад хэлний үг хэллэг сурах, багаар ажиллаж сурахад нь ач холбогдолтой байна.



- Хөтөлбөрийн шинэчлэл, өөрчлөлтийг хэлэлцсэн талаарх хөтөлбөрийн хороо, тэнхимийн хурлын тэмдэглэл бүрэн.

#### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн шинэчлэл, өөрчлөлтийг хэлэлцсэн талаарх хөтөлбөрийн хороо, тэнхимийн хурлын тэмдэглэл бүрэн хэдий ч хөтөлбөр боловсруулагч, хэрэгжүүлэгч багш нарт хүргэх мэдээлэл дутуу.
- Хөтөлбөрийн дэд хороонд хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нарын төлөөлийг заавал оруулж, хөтөлбөрийн дэд хороогоо шинэчлэн зохион байгуулах.

### **1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ:**

**Бүрэн хангасан**

#### **Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа**

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

##### **2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл**

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Үр дүнд суурилсан боловсрол (ҮДСБ) болон олон улсын инженерийн боловсролын шинэчлэлийн CDIO аргачлалыг хөтөлбөрийн агуулгатай уялдуулж сургалтын үйл ажиллагааг явуулахаар зорьж байна.
- Сургалтын төлөвлөгөөг боловсруулахдаа хичээл хоорондын харилцан уялдаа, залгамж холбоотой байх, орчин үеийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байх, давхардалгүй байх, онол практикийн зохих мэдлэг, чадвар, дадал олгоход чиглэсэн байх зэрэг зарчмуудыг харгалзсан байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- ШУТИС-ийн бүх сургалтын хөтөлбөрүүд нийтлэг арга зүйн дагуу боловсролын зорилго, зорилтуудаа тодорхойлдог.

### **Анхаарах асуудал:**

- Гадаад хэлний суурь мэдлэгийг олгоход чиглэсэн хичээл жин дарж, хэлэхүйн чадвар тус бүрээр харилцааны ур чадвар, цогц чадамжийг хөгжүүлэхэд чиглэсэн хичээл цөөн байна.
- Хөтөлбөрт сонгон судлах хичээлийн эзлэх хувь бага, чөлөөт сонголтын хичээл бараг байхгүй.

### **Зөвлөмж:**

- Сургалтын хөтөлбөрийг шинэчлэн сайжруулахад гадаад хэлний боловсролтой холбоотой олон улсын статус бүхий бодлогын бичиг баримт(Европын олон хэлний суурь хөтөлбөр CEFR гэх мэт)-ын үзэл баримтлалаас тусгах, тухайлбал хэлний зорилтот түвшинг тодорхойлох, сургалтын хэрэглэгдэхүүн дэх хичээлийн зорилго, зорилтыг Can-Do Statement илэрхийллийн дагуу тодорхойлох гэх мэт.
- Хөтөлбөрийг сайжруулахад оролцогч талуудын санал хүсэлтийг тус тусын хөтөлбөрт тодорхой тусгах.

## **2.2 Сургалтын арга зүй**

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийг Үр дүнд суурилсан боловсрол (ҮДСБ) болон олон улсын инженерийн боловсролын шинэчлэлийн - CDIO сургалтын дэвшилтэд аргууд, олон улсын магадлан итгэмжлэлийн байгууллага (ACBSP) - ын шалгуур үзүүлэлтүүд зэргийг үндэслэн дотоод нөөц боломжид тулгуурлан сургалтын арга зүйгээ тодорхойлон, хөгжүүлж ирсэн.
- Сургалтын удирдлагын системийг нэвтрүүлэн ашиглаж хэвшсэн, цахим сургалтын тодорхой туршлагыг хуримтлуулсан.

### **Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Сургуулийн хэмжээнд нээлттэй их сургууль болох бодлогыг хэрэгжүүлж, цахим контент боловсруулах суурь тавигдаж байгаа.

### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, хичээлийн суралцахуйн үр дүнгийн холбоо уялдаагүй, хичээлийн цөм агуулга нь хичээлийн суралцахуйн үр дүнтэй уялдаагүй.
- Суралцахуйн үр дүнг үнэлэх рубрикийн үнэлгээг хичээлийн хөтөлбөрт тусгаагүй.
- Сургалтын ямар ямар аргуудыг хэрэглэдэг тухай хийсэн нэгдсэн судалгаа хөтөлбөр тус бүрд байхгүй, суралцагч төвтэй идэвхтэй сургалтын аргуудыг хэрхэн ашигладаг талаарх дүн шинжилгээ хомс байна.
- Хөтөлбөрийн зорилгод заасан байгаа математик статистикийн аргыг хэл шинжлэлийн судалгаанд ашиглах ур чадварыг ямар хичээлээр олгодог болох нь тодорхойгүй.

### **Шаардлага:**

- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, хичээлийн суралцахуйн үр дүнгийн уялдаа холбоог нягталж, хичээлийн хөтөлбөрүүдийг засах.
- Хичээлийн цөм агуулга нь хичээлийн суралцахуйн үр дүнтэй уялдаатай байхаар засах.
- Суралцахуйн үр дүнг үнэлэх рубрикийн үнэлгээг хичээлийн хөтөлбөрт тусгах.

## **2.3 Суралцагчийн үнэлгээ**

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрөөр олгож буй хичээл нэг бүрийн стандарт хөтөлбөрт тухайн хичээлийг үнэлэх үнэлгээний арга тусгагдсан байх бөгөөд мэргэжлийн хөтөлбөрөөр олгох ур чадвараас тухайн хичээл ямар ур чадвар олгож байгаа, олгож байгаа ур чадвар тус бүрд нь таарсан үнэлгээний аргыг заавал тусгаж, хөтөлбөрийн дэд хороогоор хэлэлцүүлэн батлуулдаг.
- Сурлагын болон бусад амжилт гаргасан суралцагчдад кредитийн урамшуулал олгох журам үйлчилдэг.

### **Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

### **Анхаарах асуудал:**

- Оюутны сурлагын амжилт, чанарын өөрчлөлтөд хийсэн судалгаа хомс байгаа тул тогтмол хийж, дүн шинжилгээ хийх.
- Сургалтанд суралцагчийн өөрийн үнэлгээ, рубрик үнэлгээ, Блумийн таксономи зэрэг орчин үеийн үнэлгээний аргыг ашиглаж хэвшээгүй

### **Шаардлага:**

- Хичээлийн хөтөлбөрт суралцахуйн үр дүнг үнэлэх үнэлгээний арга зүй, тухайлбал рубрик үнэлгээ, Блумийн таксономи зэрэг үнэлгээний арга зүйг тусгах.

## **2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ:**

### **Хэсэгчлэн хангасан**

#### **Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл**

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

#### **3.1 Сургалтын орчин**

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Сургалтад хэрэглэгдэж байгаа анги танхим, лабораторийн хүртээмжийг сайжруулах үүднээс PDCA дүн шинжилгээ хийж хяналт үнэлэлт хийж сайжруулж, стандарт гаргасан. Хүснэгт 3.1
- Сургалтын орчинг бүрдүүлэхээр хэл хэлний анги шинээр байгуулсан.- Багш нарын ажиллах орчинг сайжруулж 324 дүгээр өрөөг 2021 оноос хятад хэлний багш нарын өрөө болгон тохижуулсан.
- Утасгүй интернэт сүлжээг 2012 онд нэвтрүүлсэн.
- Номын сангийн нөхцөл, үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэхээр зорьж BS library программ нэвтрүүлсэн.
- Хичээлийн бус цагаар оюутан сургууль дээр байх орчин нөхцөлийг тогтмол сайжруулж байгаа.

## **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Багш, оюутанд олон чиглэлээр үйлчилгээ үзүүлэх төвүүдтэй. /Эрүүл мэнд, Оюутны соёл үйлчилгээний алба, Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв, Нээлттэй боловсролын төв, Багш хөгжлийн төв, Эрдэм шинжилгээ судалгааны төв /
- 2017-2022 онд нийт 35.978 сая төгрөг сургалтын орчныг сайжруулах үйл ажиллагаанд зарцуулжээ.
- Өрөө тасалгаа, анги танхимын гэрэлтүүлэг, агааржуулалт холбоглох бичиг баримт хууль тогтоомжид заасан норм нормативыг хангасан.
- Сургуулийн эзэмшлийн талбайн 20 %-ийг зүлэгжүүлсэн.
- Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын БНБД 21-01-02 шаардлагыг бүрэн хангасан.
- Холбогдох сэтгэл ханамжийн судалгааг тогтмол хийдэг.
- Хичээлийн бус цагаар оюутан сургууль дээр байх орчин нөхцөлийг тогтмол сайжруулж байгаа.
- Дугуйн зогсоолтой

### **Анхаарах асуудал:**

- Өөрийн үнэлгээний тайланд “Хятад: 1 хүнд 1.27 м<sup>2</sup> талбай оногдож анги танхимийн нийт суудлын тоо 132 байна. Солонгос: 1 хүнд 1.36 м<sup>2</sup> талбай оногдож анги танхимийн нийт суудлын тоо 240 байна. Япон 1 хүнд 1.27 м<sup>2</sup> талбай оногдож анги танхимийн нийт суудлын тоо 132 байна.” гэж өгүүлсэн нь зөв бодитой нь эргэлзээтэй. Оюутны тоо, анги танхимын хангамжийг бодоход хоёр хөтөлбөр яг ижил гарах боломжгүй.
- Бодит байдал дээр ажиллахад байрнуудын ариун цэврийн өрөө эрүүл ахуйн шаардлага хангахааргүй байна.

### **Зөвлөмж:**

- Тайланд үнэн зөв тоо баримт, мэдээлэл оруулах.
- Сургуулийн зүгээс хичээлийн байрнуудын ариун цэврийн өрөөг эрүүл ахуйн стандартад нийцүүлэн сайжруулах арга хэмжээг авах.

### **3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн**

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Дэд системүүдэд байнга хөгжүүлэлт хийдэг.
- Бүтээлийн хуулбарлалт шалгах программ нэвтрүүлсэн.
- Багшийн вэб, оюутны вэб, номын сангийн системтэй.
- Сургалтад хэрэглэгдэх программ хангамж, компьютер, ном, сурах бичгийн хүрэлцээ, хүртээмж сайн.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг. Үүнд: UNIMS, SPSS, Google classroom, Microsoft Office 365 A-1 TEAMS. Хүснэгт 3.3
- Сургалтад хэрэглэгдэж байгаа техник хэрэгсэл, интернэт үйлчилгээний талаар тогтмол судалгаа хийж, судалгааны мөрөөр шаардлагатай ажлуудыг хийсэн. 2011 онд утасгүй интернэтэд холбогдсон, Интернэт хурд 500 Mbps, MUST WiFi хурд 1000 Mbps

#### **Анхаарах асуудал:**

- Япон хэлний орчуулгын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланд: Тайлант хугацаанд буюу 5 жилд хандиваар 405.200 төгрөгийн ном хүлээн авч, 81.040 төгрөгийн ном, сурах бичиг худалдан авсан нь хангалттай үзүүлэлт биш..
- Е-контент түвшинд боловсруулсан сургалтын материал боловсруулсан эсэх нь тайланд тусгагдаагүй.

#### **Зөвлөмж:**

- Е-контент түвшинд боловсруулсан сургалтын материал боловсруулах.
- Тайлан үнэн зөв тоо баримт, мэдээлэл оруулах. Тайланг ойлгомжтой, тодорхой бичих шаардлагатай.

### **3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- ШУТИС нь 6 давхар бүхий номын сангийн байртай.
- Номын сангийн мэдээллийн сан хангалттай сайн. Хүснэгт 3.6
- Тус хөтөлбөрийн оюутнуудад нэн шаардлагатай болон тоо хэмжээ хүрэлцэхгүй байгаа ном, сурах бичгийг ШУТИС-ийн хэвлэх үйлдвэрт эхийг өгч хэвлүүлж ашигладаг.
- Монголын Номын Сангуудын Консорциумын гишүүн болж, Олон улсын болон төрийн байгууллагуудын цахим мэдээллийн санг үнэ төлбөргүй ашиглаж байгаа нь багш, суралцагсдад эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх боломжоор хангасан.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- Ном, сурах бичгийн төрлийг байнга баяжуулдаг.
- ГХС-ийн хөтөлбөрийн номын эх үүсвэр нь хандив. Үүнд: Сургууль, багш, хамтрагч байгууллагуудын хандив.
- Багш нарын бичсэн сурах бичгийг сургуулиас дэмжин хэвлүүлдэг.

##### **Анхаарах асуудал:**

- Цөөн тоотой сурах бичгүүдийг ШУТИС-ийн хэвлэх үйлдвэрт олшруулж хэрэглэдэг гэж тайланд дурдсан байсан нь оюуны өмч, зохиогчийн эрхийн асуудалд орох магадлалтай тул анхаарах

##### **Зөвлөмж:**

- Сургуулиас хөрөнгө оруулалт хийж хэрэгцээ шаардлагатай гадаад хэлний ном ном сурах бичиг, гарын авлагуудыг худалдан авч өгөх шаардлагатай.

**3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ:**

**Бүрэн хангасан.**

## Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

### 4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

#### Илрэл нотолгоо:

- 2017 онд Гадаад хэлний сургуульд хөтөлбөрийн дэд хороо байгуулагдан, хөтөлбөрийн чанар сайжруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж, 2021 онд дэд хорооны бүрэлдэхүүнийг шинэчилсэн.
- Хөтөлбөрийн дэд хороо жил бүр ажлын төлөвлөгөөгөө батлуулан ажлаа зохион байгуулдаг.
- Төгсөгчдөөс ажил эрхлэлтийн судалгааг 2017-2021оны хооронд авч, үр дүнд суурилан сайжруулах арга хэмжээ авдаг бөгөөд суралцагчдаас сэтгэл ханамжийн судалгааг авч хэвшсэн нь оролцогч талуудын санал бодлыг хөтөлбөрийн сайжруулалтад тусгаж ирсэн.

#### Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

#### Анхаарах асуудал:

- Төгсөгчийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгийн тайланг хөтөлбөрөөр гаргаж, тайланд гарсан санал, сайжруулах үйл ажиллагааг нарийвчлан тусгах.

### 4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

#### Илрэл нотолгоо:

##### Хятад хэл

- БНХАУ-ын Шандун ШУТИС, Хойд хятадын эрчим хүчний их сургуультай хамтарсан хөтөлбөр, урт богино хугацааны сургалт, дадлага хэрэгжүүлж байна.



- Дотооддоо МУИС-ийн Күнзийн институт, МУБИС-ийн Күнзийн институт, БНХАУ-аас Монгол улсад суугаа элчин сайдын яамтай хамтран ажилладаг.
- Тайлангийн хугацаанд Хятадын сайн дурын 13 багш ажилласан.
- Тайлангийн хугацаанд 8 оюутан 1 жилийн оюутан солилцооны хөтөлбөрт хамрагдаж, 4 оюутан зуны хөтөлбөрт хамрагдсан.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хамтран ажилладаг БНХАУ-ын их сургуультай 1 жилийн оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн нь оюутнуудын хятад хэлний мэдлэгийг дээшлүүлэхэд чухал нөлөө үзүүлнэ.
- Оюутнуудын мэргэжлийн дадлагыг хамтран ажиллагч гадаад дотоодын хөрөнгө оруулалттай компанид хийлгэж эхэлсэн.

### **4.3 Санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгж шууд захиран зарцуулах эрх мэдэл бүхий эрхзүйн зохицуулалт байхгүй үйл ажиллагааны төсвийг нэгдсэн байдлаар боловсруулж батлуулдаг.
- Өөрийн үнэлгээний тайлангаас үзэхэд багш, оюутанд чиглэсэн үйл ажиллагаанд зориуж зарцуулж буй зардал харьцангуй өндөр байна.
- Багш хөгжилд зориулж сургалт, мэргэжил дээшлүүлэх, шагнал урамшуулал, томилолт, баяр ёслол, эрүүл мэнд, ахмад багш гэх үзүүлэлтээр санхүүжилт олгож ирсэн.
- Оюутан руу чиглэсэн зардлын хувьд сургалттай шууд холбоотой, сургалттай холбоотой шууд бус зардал, оюутны үйлчилгээний зардлаар ангилан санхүүжилт олгож ирсэн.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Тайлангаас үзэхэд хөтөлбөр сургалтын төлбөрөөс гадна, бусад эх үүсвэрээс олж буй орлогын дүн нийт орлогын 31%-ийг эзэлж байгаа нь хөтөлбөр орлогын олон эх үүсвэртэй болж чадсаныг илтгэж байна.

#### **Анхаарах асуудал:**

- Багшийн хөгжилд зарцуулагдаж буй зардал жил бүр буурсан үзүүлэлт гарсан тул зардлыг тогтворжуулахад анхаарах.
- 2022 онд Оюутны эрдэм шинжилгээний үйл ажиллагаанд зориулж мөнгө зарцуулаагүй нь оюутны сурах үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх магадлалтай учир цаашид багш, оюутны эрдэм шинжилгээний зардлыг тогтмолжуулж, тасралтгүй санхүүжилт хийх нь чухал.

#### **Зөвлөмж:**

- Хэдийгээр нэгдсэн санхүүжилттэй боловч цаашид орлого зардлын мэдээллийг аль болох хөтөлбөр тус бүрээр ялгаж тооцох нь илүү зохистой.

#### **4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь хөтөлбөр сурталчлах, олон нийтэд таниулах зорилгоор ШУТИС-ийн вэб хуудас, page хуудас, ШУТИС-ийн сэтгүүл, facebook групп зэргээр дамжуулан идэвхжүүлэлтийг хийдэг.
- ШУТИС дотор хөтөлбөрийг танилцуулах өдөрлөг, клубийн арга хэмжээг тогтмол зохион байгуулж ирсэн.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн сурталчилгааг ШУТИС дотор эсвэл ижил мэргэжлийн бусад сургуулиудын дунд зохион байгуулагдаж буй арга хэмжээгээр дамжуулж хийгдэж байна. Маркетингийн идэвхжүүлэлтийн арга хэмжээ нь ЕБС-ын суралцагчид рүү чиглэсэн байвал илүү үр дүнтэй.

#### **Зөвлөмж:**

- Маркетингийн идэвхжүүлэлтийг зөвхөн нэгдсэн байдлаар хийх бус, хэл тус бүр зорилтод бүлэг рүү, хөтөлбөрийн онцлог давуу талыг илэрхийлэх идэвхжүүлэлтийг эрчимжүүлэх зайлшгүй шаардлагатай.

#### **4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэхдээ сургуулийн вэбсайт <https://must.edu.mn>, Гадаад хэлний сургуулийн вэбсайт <http://fls.edu.mn/mn/>, оюутны вэб, сургуулийн facebook, оюутны facebook, сургуулийн сэтгүүл, цахим шуудан болон брошур зэргийг ашигладаг.
- Сургуулийн вэбсайт, facebook хуудасны хэрэглээ идэвхтэй, мэдээллийн шинэчлэл тогтмол хийгдэж байна. Оролцогч, сонирхогчид шаардлагатай мэдээллийг ил тод, нээлттэй авах боломж бүрдсэн.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ:  
Бүрэн хангасан**

### **Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа**

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

#### **5.1. Суралцагч сонгох, элсүүлэх**

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

**Илрэл нотолгоо:**

- БШУЯ-ны “Оюутан элсүүлэх журам”, ШУТИС-ийн захирлын тушаалыг үндэслэн боловсруулсан “Бакалаврын хөтөлбөрт суралцагч элсүүлэх журам”-ыг баримтлан оюутан элсүүлдэг.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрөөр элссэн суралцагчдын тоо 3 хэлэнд цөөн байна.

**Зөвлөмж:**

- Цаашид гадаад хэлний орчуулагч(солонгос хэл, япон хэл, хятад хэл)-ийн хөтөлбөрөөр суралцагчдын тоог нэмэгдүүлэх тал дээр бодлогын хүрээнд анхаарах.

#### **5.2. Зөвлөн туслах үйлчилгээ**

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- “Оюутны хөгжил, соёл үйлчилгээний алба”-тай хамтран ажилладаг.
- Хөтөлбөрт хамрагдаж байгаа оюутнуудын зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээг сургалтын алба, зөвлөх багш, ОХСҮА, оюутны холбоо, оюутны клубийн оролцоотойгоор тасралтгүй явуулдаг.
- “ШУТИС-ийн бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журмын 8-р бүлэгт” Зөвлөх багшийн ажлын байрны тодорхойлолт, үүрэг хариуцлагыг тодорхойлон заасан.
- ГХС-ийн албан ёсны вэб сайт <http://fls.edu.mn/>, удирдлагын мэдээллийн системээр дамжуулан сургалтын үйл явц, бусад мэдээ мэдээллийг хүргэдэг.
- “Орлоготой оюутан” хөтөлбөрийн хүрээнд ШУТИС-ийн Оюутны соёл, үйлчилгээний алба Нийслэлийн хөдөлмөр, эрхлэлтийн газартай байгуулсан санамж бичгийн хүрээнд оюутнуудыг байнгын болон цагийн ажлын байранд зуучилдаг.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Суралцагчдад зөвлөн туслах үйлчилгээ тодорхой хэмжээнд тогтмолжсон байна.

#### **Анхаарах асуудал:**

- Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тал дээр Оюутны соёл, үйлчилгээний алба болон салбар сургууль, баг, багшийн хамтын ажиллагааг сайжруулах

### **5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо**

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

